

# ИНДЕКСЖҮҮЛСЭН ГЭРЭЭНИЙ ҮНИЙГ БОДОХ ТОМЪЁО

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны журам"-ын

Хавсралт 6.

/Энэ хавсралтыг Төлөвлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 48 дугаар тогтоолоор өөрчилсөн./

## ИНДЕКСИЙН ХӨДӨЛГӨӨН ТООЦОХ АРГАЧЛАЛ

Индексийн хөдөлгөөнийг МХБ-ээс сар бүрийн 05-ны өдрийн дотор цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Мэдээлэхдээ тухайн индексийн хөдөлгөөний үзүүлэлтийг өссөн тохиолдолд нэмэх (+) тэмдэг, буурсан тохиолдолд хасгах (-) тэмдгээр тус тус тэмдэглэнэ. Хэрэв тухайн сарын 05-ны өдөр хагас сайн өдөр таарвал 04-нд, бүтэн сайн өдөр таарвал дараагийн өдөр буюу 06-ны өдөр, 3 ба түүнээс дээш хоногийн бүх нийтийн амралтын өдөр таарсан тохиолдолд тухайн сарын 05-ны өдөртэй аль ойрхон ажлын өдөр нийтэлнэ.

- Коксжих болон эрчим хүчний нүүрснээс бусад төрлийн нүүрсний гэрээний үнэд дээрх индексийн хөдөлгөөн хамаарахгүй
- Хэлцэл хийгдсэн 1 болон 2 дахь сарын гэрээний үнийг хэлцлийн үнээр тооцож, 3 дахь сарын гэрээний төлбөрийг индексийн хөдөлгөөнд суурилсан үнээр тооцож эхэлнэ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалагдсан коксжих нүүрс болон эрчим хүчний нүүрсний индексийн сагсны хөдөлгөөнийг тооцохдоо дор дурдсан дэс дарааллыг баримтална. Үүнд:

1. Индексүүдийн сарын дундаж утгыг тооцоолно;

Индекс бүрийн тухайн сарын арифметик дундаж олох замаар тооцоолно.

$$I_n(t) = \frac{\sum I_i}{d}$$

- $I_n(t)$  –  $n$  индексийн тухайн сарын дундаж үзүүлэлт
- $I_i$  – тухайн өдрийн үзүүлэлт
- $d$  – тухайн сарын нийт өдрийн тоо

2. Индексүүдийн сар бүрийн хөдөлгөөний коэффициентыг тодорхойлно.

Индекс бүрийн сарын дундаж үзүүлэлтийг өмнөх сартай харьцуулах замаар хөдөлгөөнийг /өөрчлөлтийн коэффициент/ тодорхойлно.

$$\Delta INDEX_n(t) = \frac{I_n(t) - I_n(t-1)}{I_n(t-1)} * 100\%$$

- $\Delta INDEX_n(t)$  – тухайн сарын  $n$  индексийн хөдөлгөөний коэффициент
- $I_n(t)$  –  $n$  индексийн тухайн сарын дундаж үзүүлэлт
- $I_n(t-1)$  –  $n$  индексийн өмнөх сарын дундаж үзүүлэлт

3. Индексийн сагсны өөрчлөлтийн хөдөлгөөний коэффициентыг тодорхойлно.

Тухайн сарын индексийн сагсны өөрчлөлтийн хөдөлгөөний коэффициентыг тодорхойлохдоо индекс бүрийн тухайн сарын үзүүлэлтийг сагсанд эзлэх хувийн жинд нь үржүүлж тооцоолно.

$$\Delta INDEXbasket(t) = w_1 * \Delta INDEX_1(t) + w_2 * \Delta INDEX_2(t) + w_3 * \Delta INDEX_3(t) + w_4 * \Delta INDEX_4(t) + w_5 * \Delta INDEX_5(t) + w_6 * \Delta INDEX_6(t)$$

- $\Delta INDEXbasket(t)$  – тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент

- $w_n$  –  $n$  индексийн сагсанд эзлэх хувийн жин
- $INDEX_n(t)$  – тухайн сарын  $n$  индексийн хөдөлгөөний коэффициент

4. Индексийн сагсны хөдөлгөөний коэффициентыг ашиглан коксжих болон эрчим хүчний нүүрсний сар бүрийн үнийн хөдөлгөөнийг тодорхойлно.

Гэрээний эхний сард хэлцлийн үнийг индексийн хөдөлгөөний коэффициент ашиглан өөрчилнө.

$$P_t = P_0 * (1 + \Delta INDEXbasket(t))$$

- $P_t$  – тухайн сарын үнэ
- $P_0$  – хэлцлийн үнэ
- $\Delta INDEXbasket(t)$  – тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент

Гэрээний 2 дох сараас өмнөх сарын буюу индексийн хөдөлгөөнийг тооцсон үнээс тухайн сарын индексийн хөдөлгөөний коэффициент ашиглан өөрчлөх зарчмаар үргэлжилнэ.

$$P_t = P_{t-1} * (1 + \Delta INDEXbasket(t))$$

- $P_t$  – тухайн сарын үнэ
- $P_{t-1}$  – хэлцлийн үнэ
- $\Delta INDEXbasket(t)$  – тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент

Индексийн хөдөлгөөн  
тооцох аргачлал

Индексийн сагсны  
хөдөлгөөний  
коэффициент

Огноо	Коксжих нүүрсний индексийн хөдөлгөөн	Эрчим хүчний нүүрсний индексийн хөдөлгөөн
2025-03 сар	-5.76%	-
2025-04 сар	-1.96%	-
2025-05 сар	-2.63%	-
2025-06 сар	-6.28%	-
2025-07 сар	+5.67%	-
2025-08 сар	+11.33%	-
2025-09 сар	+2.10%	+0.44%
2025-10 сар	+6.39%	+7.13%
2025-11 сар	+4.51%	+10.67%
2025-12 сар	-5.03%	-6.52%

Томъёо:

Индексийн сагсны хөдөлгөөний коэффициентыг ашиглан коксжих болон эрчим хүчний нүүрсний сар бүрийн үнийн хөдөлгөөнийг тодорхойлно.

Хэлцэл хийгдсэнээс хойш хуанлийн 3 дах сард хэлцлийн үнийг индексийн хөдөлгөөний коэффициент ашиглан өөрчилнө.

$$P_t = P_0 * (1 + \Delta INDEXbasket(t))$$

–  $P_t$  – тухайн сарын үнэ

–  $P_0$  – хэлцлийн үнэ

–  $\Delta INDEXbasket(t)$  – тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент.

Хэлцэл хийгдсэнээс хойш хуанлийн 4 дэх сараас эхлэн индексийн хөдөлгөөнийг тооцсон өмнөх сарын үнээс тухайн сарын индексийн хөдөлгөөний коэффициент ашиглан өөрчлөх зарчмаар үргэлжилнэ.

$$P_t = P_{t-1} * (1 + \Delta INDEXbasket(t))$$

–  $P_t$  – тухайн сарын үнэ

–  $P_{t-1}$  – өмнөх сарын үнэ

–  $\Delta INDEXbasket(t)$  – тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент.

# ИНДЕКСЖҮҮЛСЭН ГЭРЭЭНИЙ ҮНИЙГ БОДОХ ЖИШИГ ЗАГВАР

## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ФОРВАРД ГЭРЭЭНИЙ АРИЛЖААНЫ ЗАР

1	Худалдагч этгээдийн нэр	"Эрдэнэс Тавантолгой" ХК
2	Арилжаа зохион байгуулагдах огноо, цаг	2025/06/25 (Даваа гараг) 11:00 цаг
3	Уул уурхайн бүтээгдэхүүний төрөл, ангилал	1/3 коксжих нүүрс
4	Чанарын үзүүлэлт	Ash (db): ≤9.0 Total moisture (ar): ≤5.0 Volatile (daf): >28.0-37.0 Total sulphur (db): ≤1.0 G-index (5.1): ≥75.0
5	Багцын тоо, нийт хэмжээ	20 багц буюу нийт 128,000 тонн
6	Дуудах доод үнэ, валютын төрөл	110.5 ам.доллар/тн
7	Тогтмол үнэтэй эсхүл индексэд суурилсан үнэтэй захиалга эсэх	Индексэд суурилсан үнэтэй
8	Чанарын зөрүүнд тооцох үнийн нэмэгдэл, бууралт байгаа эсэх, тооцох аргачлал	Байхгүй
9	Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн	0.5 ам.доллар
10	Гэрээ дуусгавар болох хугацаа	180 хоног
11	Хүргэлт хийх хугацаа, нөхцөл /хэсэгчилж хүргэлт хийх тохиолдолд хүргэлтийн хуваарь/	2025/11/25 (нийлүүлэлтийн хуваарийн дагуу хугацааны эцэст нийлүүлж дууссан байна)
12	Бүтээгдэхүүн нийлүүлэх цаг	БНХАУ, Ганцмод боомт дахь худалдан авагчийн нэрлэсэн гаалийн хяналтын бүс
13	Тээвэрлэлтийн төрөл	Авто зам болон төмөр зам
14	Данчингийн хэмжээ	Биржийн худалдан авагч – 1,414,400 ам.доллар Брокер – 707,200 ам.доллар
15	Данчин байршуулах банкны дансны мэдээлэл, валютын төрөл	Хүлээн авагч : MONGOLIAN STOCK EXCHANGE JSC Хүлээн авагчийн банк : TRADE AND DEVELOPMENT BANK OF MONGOLIA Свифт код : TDBMMNUB Дансны дугаар : MN 94000 4000 499186166 Банчны хаяг : TRADE AND DEVELOPMENT BANK, 14210 PEACE AVENUE 19, SUKHBAATAR DISTRICT, 1ST KHOROO, ULAANBAATAR, MONGOLIA Tel: (+976) 70161998 Хүлээн авагч : MONGOLIAN STOCK EXCHANGE JSC Хүлээн авагчийн банк : ХАСBANK Свифт код : SAXBMNUB Дансны дугаар : MN 6400 3200 5005595301
16	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл	Банчны хаяг : ULAANBAATAR ХАСBANK HQ BLDG, ULAANBAATAR-14200, Худалдан авагч тал чингэлэг болон түүнтэй холбогдох бүхий л зардлыг хариуцах ба 200-с доошгүй чингэлэг бэлтгэх.
17	Биржийн мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар	976-11-313747 (6113)

Энэхүү маягтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг худалдагч тал бүрэн хариуцна. Хэрэв Монгол, Англи, Хятад хэл дээрх зарын мэдээлэл хоорондоо зөрөх тохиолдолд Монгол хэл дээрх зарыг зөв гэж үзнэ.

### БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

Нийлүүлэх хугацаа	2025/06	2025/07	2025/08	2025/09	2025/10	2025/11
Төлбөр төлөх хугацаа	Ажлын 7 хоногт Гэрээний нийт үнийн дүнгийн 25%	-	Индексийн хөдөлгөөнд суурилсан үнээр			
Нийлүүлэх хэмжээ /тонн/	21,000	21,000	21,000	21,000	21,000	23,000

## Томъёо:

$$P_t = P_0 * (1 + \Delta INDEXbasket(t))$$

-  $P_t$  – тухайн сарын үнэ

-  $P_0$  – хэлцлийн үнэ

-  $\Delta INDEXbasket(t)$  - тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент.

$$P_t = P_{t-1} * (1 + \Delta INDEXbasket(t))$$

-  $P_{t-1}$  – тухайн сарын үнэ

-  $P_{t-1}$  – өмнөх сарын үнэ

-  $\Delta INDEXbasket(t)$  - тухайн сарын сагсны индексийн хөдөлгөөний коэффициент.

## Бодолт:

Огноо	Хэлцлийн үнэ	Нийлүүлэх тоо хэмжээ	Тухайн сарын индексийн хөдөлгөөн	Гэрээний нэгж үнийн өөрчлөлт	Тухайн сарын гэрээний үнийн бодолт
2025.06-р сар	110.5\$	21,000 тн	-6.28%	110.5\$ (өөрчлөлт орохгүй)	110.5\$ *21,000 тн = 2,320,500\$
2025.07-р сар		21,000 тн	+5.67%	110.5\$ (өөрчлөлт орохгүй)	110.5\$ *21,000 тн = 2,320,500\$
2025.08-р сар		21,000 тн	+11.33%	110.5\$ x (1+11.33%)=123.02\$	123.02\$ *21,000 тн = 2,583,413\$
2025.09-р сар		21,000 тн	+2.10%	123.02\$ x (1+2.10%)=125.60\$	125.60\$ *21,000 тн = 2,637,664\$
2025.10-р сар		21,000 тн	+6.39%	125.60\$ x (1+6.39%)=133.63\$	133.63\$ *21,000 тн = 2,806,211\$
2025.11-р сар		23,000 тн	+4.51%	133.63\$ x (1+4.51%)=139.66\$	139.66\$ *23,000 тн = 3,212,083\$

Индексжүүлсэн гэрээний нийт үнэ: **15,880,371 \$**

